

Ц.Баатартогтох, дэд профессор, доктор.

Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
Удирдлагын академийн социологи, сэтгэл зүйн тэнхим

## ТАНИН МЭДЭХҮЙН ДУАЛИЗМЫН ТӨГСГӨЛ

**Түлхүүр үг:** танин мэдэхүй, мэдлэг, мэдээлэл, сигнал, мэдрэхүй, сэдэхүй, ухаан, оюун, эмпиризм, рационализм, a priori, a posteriori

Энэ өгүүлэлд танин мэдэхүй, мэдлэгийн сурвалжийн тухай асуудлыг уламжлалт эмпиризм, рационализмын аль алиных нь үүднээс авч үзэх нь физиологи, психологи, мэдээллийн зэрэг шинжлэх ухааны баримтаар үндэслэгдэх боломжгүй байгааг харуулах, энэ асуудалд өөр байр сууринаас хандахыг зорьсон болно. Үүнд:

Мэдрэхүйн эрхтнээр дамжин уураг тархинд очдог өгөгдлийг мэдлэг гэж үзсэнээр нэг талаас эмпиризм, нөгөө талаас эмпиризмыг үл зөвшөөрөхдөө танин мэдэхүй нь мэдрэхүйн эрхтний өгөгдөл, мэдээллээс огт хамааралгүй "цэврээрээ" оршдог гэж үздэг рационализм хоёр нь хоёулаа гносеологи алдаатай үндэслэл дээр, баримтыг буруу тайлбарласан ойлгохуй дээр суурилж иржээ. Үнэн хэрэгтээ, өнөөгийн физиологи, психологи, мэдээллийн шинжлэх ухааны үүднээс мэдрэхүйн эрхтнээр дамжин тархинд хүрч очдог өгөгдөл нь цаашдаа кодлогдон мэдээлэл болж хувирдаг сигнал, мөн цаашдаа боловсруулагдаж мэдлэг болдог /гэхдээ хараахан мэдлэг болоогүй, боловсруулагдаагүй/ мэдээлэл юм байна. Тиймээс мэдрэхүйн эрхтний өгөгдлийг мэдлэг гэж үзэж болохгүй нь байна. Нөгөө талаас "рационал" танин мэдэхүй, мэдлэг нь ч мэдрэхүйн эрхтний өгөгдөл, мэдээлэлгүйгээр, түүнээс ангид, цэврээрээ мөн бий болдоггүй байна. Ингэж үзвэл нэг талаас "мэдэрч танин мэдэхүй" гэж нэрлэж ирсэн тэр процесс нь "танин мэдэхүй биш" харин танин мэдэхүйн үйл ажиллагааны мэдээлэл, өгөгдөл олж авдаг механизм болж, нөгөө талаас "рационал танин мэдэхүй" гэж ойлгож ирсэн тэр үйл явц нь ч бас мэдрэхүйн эрхтнээс өгөгдөл, мэдээлэл огт авдаггүй Платон болон И. Кантын хэлсэн шиг туршлага, мэдрэхүйгээс огт хамааралгүй, "цэвэр" оршиж байдаггүй, харин мэдрэхүйн эрхтний өгсөн мэдээллийн тусламжтайгаар "ажиллаж" байж "цэвэр биш" мэдлэг гаргадаг байна. Танин мэдэхүй нь мэдрэхүйн эрхтнээс огт мэдээлэл авдаггүй, түүнээс огт хамааралгүй "цэвэр" байдлаар оршин байх ямарч боломжгүй юм байна. Тиймээс хүн төрөлтөн эсвэл дан ганц эмпирик, эсвэл дан ганц рационал танин мэдэхүйтэй ч биш, "мэдрэхүйн" ба "цэвэр оюун ухааны" гэсэн хоёр танин мэдэхүйтэйч биш, харин мэдрэхүйн эрхтнээр дамжуулан мэдээлэл авч, уг мэдээллийг ухаанд сэдэн

Боловсруулах замгаар мэдлэг үйлдвэрлэдэг мэг л танин мэдэхүйтэй байна гэсэн санааг

Энэ санааг "рационал танин мэдэхүй" гэж нэрлэдэг байна. Энэ санааг "рационал танин мэдэхүй" гэж нэрлэдэг байна.

байгааг гарган харуулах, мэдлэг үндэслэсээ гартэх зорилго тавив.

Танин мэдэхүйд "эмпиризм", "рационализмын" асуудал буюу танин мэдэхүйн үйл явц, мэдлэгийн агуулгад хүний мэдрэхүй, ухаан хоёрын аль нь

чухал үүрэг, функцитэй байдаг тухай асуудал бараг философи үүссэн цагаас эхлэн философичдын дунд эцэс төгсгөлгүй маргааны бай болсоор өдгөө бараг гурван мянган жилийн нүүр үзэж байна. Эмпиризм ба рационализмын асуудлыг зарим философичид “сонгодог фундаментализм” гэж нэрлэдэг байна. Эмпиризм, рационализм буюу сонгодог фундаментализмын гол асуудал нь мэдрэхүйн эрхтнүүдээр дамжин хүний тархинд очдог материалан юмс, гадаад ертөнцийн тухай мэдээлэл, өгөгдөл ба хүний өөрийн сэдэн бодох ухааны үйлдлээр бүтээгддэг агаад гадаад материалан ертөнц ба оюуны ертөнцийн тухай мэдлэг “хоёрын” харьцааны тухай асуудал байдаг. Товчоор, хүн мэдрэхүйн эрхтэн ба оюун тархи хоёрын алинаар нь танин мэддэг, мэдлэг олж авдаг вэ, эсвэл энэ хоёрын аль нь илүү чухал үүрэгтэй вэ гэсэн асуудал юм. Эмпирикүүд хүн мэдрэхүйн буюу харах, сонсох, тэмтрэх, амтлах, үнэрлэх таван эрхтнээр дамжуулан танин мэддэг төдийгүй энэ нь гол шийдвэрлэх үүрэгтэй гэж үздэг. Тэгээд мэдээж мэдрэхүйн эрхтнээр дамжуулан авдаг өгөгдөл нь мэдлэг гэдэг. Тухайлбал эртний философичид зөвхөн мэдрэхүйн таван эрхтний дамжуулан өгөгдсөн зүйлийг мэдлэг мөн эсэх тухай ярьж байсан бол шинжлэх ухаанд эксперимент үүссэнээр түүний үр дүнд гарч байгаа өгөгдлийг мөн л мэдрэхүйн таван эрхтнээр дамжуулан хүлээж авч тархинд оруулж ирдгийг танин мэдэхүй, мэдлэг гэж үздэг болсноор “эмпирик танин мэдэхүй”, “туршлагын мэдлэг” гэгчийн тухай асуудал улам өргөн тархаж философид эмпиризм бие даасан сургууль болон үүсчээ. Эмпиризмыг эсэргүүцэгчид нь рационализмын янз бүрийн хувилбаруудыг бүрдүүлдэг. Тэд мэдэрч танин мэдэхүйг үгүйсгэж, үл зөвшөөрч хүн зөвхөн рационал аргаар буюу ухаанаар /сэдэхүйгээр/ таньж мэддэг гэж үздэг. Тууштай рационализмын гол төлөөлөгч бол Платон, Р. Декарт нар юм. Үүний үр дүнд танин мэдэхүйн “эмпирик” ба “рационал” гэсэн хоёр бие даасан төрөл, хэлбэр байдаг мэт төсөөлөл, ойлгохуй бий болж тэдгээрийг баримтлагчид эмпиризм, рационализм гэсэн хоёр туйлыг бүрдүүлж, танин мэдэхүй дэх “дуализм” Р. Декартаас (1596- 1650) хойшхи үеийн философид гарч тэдний хоорондын маргаан өнөө хүртэл үргэлжилж байна. Эмпиризм чухам энэ үеэс хүчтэй тархаж эхэлсэн нь мөн энэ үеэс шинжлэх ухаанд эксперимент туршилтын арга бий болж, туршилт хийдэг шинжлэх ухааны салбаруудыг “эмпирик шинжлэх ухаан” гэж ойлгох болсонтой холбоотой юм.

107

Эксперимент буюу шинжлэх ухааны туршилтыг энэ үүднээс хэрхэн үзэх тухай жич ярих болно.

Эмпиризм ба рационализмын “дуализмыг” И. Кант шийдвэрлэх оролдлого хийснийг бид мэднэ. Гэхдээ энэ асуудлыг Кант шийдэж чадаагүй гэж үздэг. Кантын хийсэн зүйлийг тайлбарлахын тулд бодит байдлыг бага зэрэг хялбарчлаад Кантаас өмнөх үед мэдлэгийн сурвалж бол мэдрэхүй гэж эмпирикүүд үздэг байхад рационалистууд түүнийг ухаан, сэдэхүй гэж үздэг гэе. Энэ бол хоёр туйл нь гэж хэлж бас болох байх. /Үнэн хэрэгтээ бол эмпиризм, рационализмын асуудал нь яг ийм энгийн биш гэдгийг та бид мэднэ/. Тэгээд Кант эмпиризм, рационализмын маргааныг шийдэхдээ мэдлэгийг дотор нь эмпирик /a posteriori/ ба рационал /a priori/ гэж ангилан хуваах замаар шийдэхийг оролджээ. Өөрөөр хэлбэл мэдлэгийн гадна байсан буюу мэдлэг бий болоход аль нь чухал вэ гэдэг асуудлыг мэдлэгийн “дотор” оруулж, түүнийг хоёрдуулан мэдлэг дотооддоо хоёр эх үүсвэртэй болгож, тэр хоёр эх үүсвэрээс зохих төрлүүд үүсдэг болгон авч үзсэн байдаг. Тэрээр нэг бол туршлага дангаараа эсвэл ухаан дангаараа мэдлэгийн сурвалж болдог гэсэн асуудлыг нэгтгэн мэдрэхүй, ухаан хоёр хоёулаа мэдлэгийн сурвалж болдог гээд түүнд тохирсон a priori ба a posteriori мэдлэг оршин байдаг ба тэдгээр нь “ухамсрын нэгдэл” гэдэг ойлголтын ачаар нэгдмэл болдог тухай онолоо гаргажээ. Тэр априори мэдлэгийг апостериори мэдлэгээс ялгах шинж тэмдэг нь зайлшгүй ба универсал шинж гэжээ. Кант философийн гаднах “дуализмыг” түүний доторхи “дуализмаар” сольсноос биш угтаа бол асуудлыг шийдэж чадаагүйг философид хүлээн зөвшөөрдөг билээ.

Эмпиризм ба рационализмын маргааныг шийдэх гэсэн нэг оролдлого бол марксизмын философи дахь танин мэдэхүйн мэдрэхүйн ба рационал үе шатны тухай асуудал юм. Марксист философид уг асуудлыг Аристотель- оос уламжлан авч танин мэдэхүйг “мэдэрч танин мэдэхүй”, сэдэж танин мэдэхүй хэмээн хүлээн зөвшөөрдөг ч тэдгээрийг бие даасан хоёр танин мэдэхүй биш нэгдмэл нэг танин мэдэхүйн хоёр үе шат гэж үздэг. Энэ бол тэдгээрийг салгаж, бие даасан танин мэдэхүй байдлаар үздэг эмпиризм, рационализмын заримаас арга зүйн хувьд илүү гэдгийг хэлэхгүй өнгөрвөл шударга биш болно. Гэхдээ энэ хандлага нь мэдэрч танин мэдэхүй, түүнд тохирсон мэдрэхүйн мэдлэг /чувственное знание/ байдаг гэж үздэгээрээ И. Кантаас илүү шинэ юм нэмээгүй гэж хэлж болно. Кантаас ялгаатай нь a priori

мэдлэгийг материалист тусгалын онолын үүднээс ор тас үгүйсгэдэгээрээ онцлог.

Эцэст нь энэ маргааныг уг асуудлыг авч үзэхгүй байх, түүнээс зугатах арга замаар “шийдвэрлэж” байгаа философичдын саналыг “орчин үеийн философи” гаргаж байна. Аливаа шийдвэрлэж чадахгүй асуудлыг хаяж, түүнээс зугатаад байвал юу болох нь мэдээж.

Ингээд сонгодог фундаментализиын асуудлыг эмпиризм, рационализм үүсэхээс өмнөх философид хэрхэн авч үзэж ирснийг үзье. Танин мэдэхүйд мэдрэхүйн эрхтний үүрэг, түүний өгөгдлийн тухай энэ асуудал нь бүр эртний философиос эхтэй.

Эртний буддын философийн зарим хэсэг болон Гераклит, Демокрит, Платон, Аристотель нарын философид уг асуудлыг авч үзсэнийг ажиглахад мэдэрч танин мэдэхүй гэж бие даасан хэлбэрийг нотлосон нь үгүй байна. Танин мэдэхүйн ба мэдлэгийн бие даасан хоёр төрөл, хэлбэр гэх мэтээр авч үзсэнгүй харин танин мэдэхүй, мэдлэг бий болоход мэдрэхүй ба сэдэхүйн үүрэг харилцан адилгүй тухай ярьсан байх юм. Жишээ нь “Махабхарата”-гийн “Мокшадхарма”, “Анугите” хэмээх хэсэгт ухаан, мэдрэхүйн үүргийг дараахь байдлаар авч үзсэн байна. Ухаан (манас) мэдрэхүйд ингэж хэлжээ: “Надгүйгээр хамар үнэрлэдэггүй, хэл амтыг мэдэрдэггүй, дүрсийг нүд багтаадаггүй, арьс хүрэхийг танихгүй, миний орхисон чих авиаг сонсдоггүй” тиймээс “бүх чанараас хамгийн чухал нь би” гэжээ. Мэдрэхүй ухааны хэлснийг бүрэн зөвшөөрөөд гэхдээ надгүйгээр ухаан та юмсын тухай зөвхөн дүрслэн бодож л чадна, мэдрэхүйгүйгээр ухаан түлшгүй гал мэт доройтно, учир нь ухаан зөвхөн мэдрэхүйн гэрчлэлүүдийн утга учрыг тунгаадаг. Мэдрэхүй бол ухааны оронгийн хаалга. “Бидэнгүйгээр чи танин мэдэж чадахгүй” гэжээ.<sup>30</sup>

Эдгээр философичид мэдрэхүйн эрхтний өгөгдлийг бие даасан мэдлэг гэж үзэхээсээ илүү ямар нэг хэлбэрээр рационал танин мэдэхүйд захируулсан, түүнтэй харьцуулбал дагавар байдлаар авч үзсэн байна. Тэдний хувьд бие даасан “мэдэрч танин мэдэхүй” гэдэг юм алга. Мөн “мэдэрч танин мэдэхүйг” туйлчилсан хүн нэг ч үгүй байхад рационал танин мэдэхүйг бүгд ямар нэг хэлбэрээр онцолсон, эсвэл туйлчилсан байгааг харж болно. “Мэдэрч танин мэдэхүйг” үгүйсгэсэн хүн байхад “рационал” танин мэдэхүйг

<sup>30</sup> Антология мировой философии. 1969. в 4 т., т. 1., ч. 1., с. 108

үгүйсгэсэн хүн алга. Харин ч бүр "рационал" танин мэдэхүйг Платон туйлчлан мэдрэхүйн эрхтнүүдийн танин мэдэхүйн үүргийг бүр үгүйсгэж "мэдрэхүй нь мэдлэгийн сурвалж ч байж чадахгүй" гэж үзсэн байна. Тэдний дотроос Буддын философийн хандлага маш сонирхолтой, эвристик нь юм. Энд ухаан, сэдэж танин мэдэхүйн үүргийг танин мэдэхүйд илүү чухал гэж үзэхдээ тэр нь мэдрэхүйн эрхтний үүрэггүйгээр хагас дутуу болно гэсэн санааг гаргасан нь маш чухал юм. Жишээ нь Платон мэдрэхүйг ор тас үгүйсгэсэн байтал энд танин мэдэхүйд мэдрэхүй ба ухааны үүрэг өөр өөр боловч нэг нь нөгөөгүйгээр үл оршин байх тухай хэлсэн нь мэдээлэлгүйгээр сэдэн бодохуй, ухаан нь хоосон ажиллана, ухаангүйгээр дан мэдээлэл мэдлэг болохгүй гэж хэлэхтэй утгаара адил байгаа юм.

Эндээс бид эртний философичид мэдрэхүйн эрхтний танин мэдэхүйд гүйцэтгэх үүргийг зөв ойлгож, "мэдэрч танин мэдэхүй" байдаг гэж үзээгүй харин одоогийнхоор бол "мэдээлэл" мэтээр үзэж байсан байна гэж дүгнэж болохоор байна. Зөвхөн Аристотелийг марксист- зөвлөлтийн философид танин мэдэхүйн эмпирик ба рационал хоёр шатны тухай санааг үндэслэсэн хэмээн үздэг боловч түүнийг бас туршлагыг /экспериментийг/ мэддэггүй үед амьдарч байсан болохоор мэдрэхүйн танин мэдэх ач холбогдлыг доошлуулсан /принижение чувственного знания/, түүний ач холбогдлыг бүрэн ойлгоогүй, мэдрэхүйн ба рационал танин мэдэхүйн диалектикийг ойлгоогүй, уг асуудлыг шийдвэрлэх чадваргүй, зөрчилтэй орхисон гэх мэт олон зүйлээр буруутгадагийг бид мэдэх билээ. Үүнээс үзвэл Аристотель ч эмпирик танин мэдэхүй байдаг гэж тууштай нотлож байсан гэж хэлэх аргагүй. Үүнийг түүний хүртэн мэдрэхүй нь бүх хүн, амьтанд нийтлэг учраас хялбар зүйл, түүнд ямар ч эрдэм байхгүй" гэсэн үг гэрчилдэг. Түүнээс гадна Аристотель мэдрэхүй нь хүнээс гадна амьтанд байдаг психологийн шинж мөн гэж мэдэж байсан төдийгүй бүр нарийн мэдэж байсан. Тухайлбал мэдрэхүйг хүн ба бүх амьтанд нийтлэг байдаг ба хүн зөвхөн зарим амьтанд нийтлэг байдаг гэж ялгаж үздэг өнөөгийн психологийн мэдлэгийг мэдэж байсан шүү дээ.

Тэгээд ч Аристотелийнхээр шинжлэх ухааны судлагдахуун нь ерөнхий ба зайлшгүй мөн. Ерөнхийн тухай мэдлэг нь бие даасан байдлаараа ухаант оюунд априор байдлаар /Платоны үзсэний адил/ оршиж байдаг ба эдгээрийн тухай мэдлэг нь мэдрэхүйн өгдөг нэгжийн мэдлэгийг нэгтгэн дүгнэх замаар биш харин нэгжийн тухай мэдлэгийн тусламжтайгаар "илэрдэг" гэж үзсэн

бидлээ. Энэ бүхнээс үзэхэд Аристотелийн мэдлэгийг үе шат, түвшинд хувааж үзсэн байдал нь танин мэдэхүйг эмпирик ба рационал гэж хуваасан биш харин мэдлэгийг ердийн, шинжлэх ухааны бус, шинжлэх ухааны хэмээн үздэгтэй адил юм. Аристотель, “Урлаг” эзэмшсэн хүмүүс нь туршлага эзэмшсэн хүмүүсийг бодвол илүү эрдэмтэй, учир нь тэд ойлголт эзэмшсэн, шалтгааныг мэддэг хүмүүс юм. Танин мэдэхүйн эцсийн шат нь шинжлэх ухаан, түүний дээд нь философи юм гэж үзээд мэдлэгийн энэ түвшиндээ тохируулан хүнийг мэдлэгийн нь түвшингээр ангилсан байна. Тиймээс Аристотелийг ч “эмпирик танин мэдэхүй” гэгчийг нотлож байсан гэж үзэх хангалттай үндэслэл алга юм.

Ерөнхийдөө эртний философид мэдрэхүйн процессыг танин мэдэхүй гэж үзээгүй ба мэдрэхүйн эрхтнүүдийн өгөгдлийг “мэдэрч танин мэдэхүй” гэж үзсэн гэх үндэс алга.

Харин танин мэдэхүйн дуализм /нэг зүйлийг хоёр хувааж салгаж үзсэн гэсэн утгаараа/ эмпиризм, рационализмын асуудал нь Декартаас, тэрээр философид “амьдрал гэдэг эцэс төгсгөлгүй зүүд мөн гэдэг аймаар төсөөллөө”<sup>2</sup> оруулж ирсэн үеэс эхэлжээ. Мөн энэ утга учиргүй бүх асуудлыг философи руу чихэж эхэлсэн үеэс, бас үүнтэй зэрэгцэн экспериментын аргыг шинжлэх ухаанд өргөн хэрэглэх болсон үеэс жинхэнэ утгаараа эхэлжээ.

Мэдрэхүйн эрхтнүүд, харах, тэмтрэх, сонсох, үнэрлэх, амтлах гэдэг мэдрэхүйн үйлдлүүд бидэнд мэдлэг өгдөг үү, эсвэл эдгээр эрхтний өгөгдөл нь шууд мэдлэг арай биш, тухайлбал мэдээлэл үү гэдгийг философийн хүрээнд дараахь үндэслэлүүдэд тулгуурлан авч үзэж болох юм.

Юуны өмнө энэ таван мэдрэхүй нь хүнээс гадна тавуулаа мал, амьтанд, миний мэдэхээр л лав таван хошуу малд байдаг. Аристотель ч /чувственное восприятие/ мэдрэн хүртэхүй нь зөвхөн хүний хувь тавилан биш бас амьтанд байдгийг хэлж байж. Өнөө ч физиологи психологи ингэж үздэг төдийгүй энэ нь хүн бүхэнд ил баримт юм. Хүн мэдрэхүйн эртнээр таньж мэддэг, мэдлэг олж авдаг гэвэл энэ таван эрхтэн нь нэгэнт тэдгээрийг агуулсан хүнд мэдлэг өгдөг юм бол адилхан тэдгээрийг агуулдаг мал амьтанд бас л мэдлэг өгдөг, мал “мэдэрч танин мэдэхүйтэй” болж байна уу? Нэгэнт л мэдрэхүй нь мэдлэг өгдөг, мэдрэхүйн эрхтнээр өгөгддөг “мэдэрч танин мэдэхүй” байдаг, объектын тухай мэдлэг мэдрэхүйн эрхтнээр дамжин хүнд

<sup>2</sup> Вольф Р. 2002 Философийн тухай. УБ.: Монсудар.

өгөгддөг гэдэг нотолгоог зөвшөөрөх юм бол логикоор мал амьтан “мэдэрч танин мэдэхүйтэй” гэж зөвшөөрөхөөс өөр аргагүй биз дээ.

Мэдрэхүйн эрхтэн мэдлэг өгдөг

Мал мэдрэхүйн эрхтэнтэй

Мал мэдлэгтэй

Гэхдээ үүнийг софизм гэж хэлэхээ түр азная. Нэгэнт малд танин мэдэхүй гэдэг оюуны үйл ажиллагаа байдаг гэж хэн нэгэн нотлоогүй болохоор мал амьтны тухайд мэдлэг, танин мэдэхүйн тухай ярьж болохгүй байна. Тэгэхээр мэдрэхүй нь өөрөө дээрхи хоёр тохиолдолд хоёуланд нь нийтлэг /мэдлэг, танин мэдэхүйн/ шалтгаан болж чадахгүй байна. Ингэхээр нэг бол мал амьтан “мэдэрч танин мэдэхүйтэй” эсвэл “мэдэрч танин мэдэхүй” гэх ойлгохуй нь буруу эсвэл “мэдэрч танин мэдэхүй” гэж нэрлэдэг тэр юм байхгүй болж таарч байна. Эсвэл хүн мал хоёрын мэдрэхүй огт адилгүй буюу үндсэндээ малын тухайд мэдрэхүйн тухай ярих боломжгүй буюу малд мэдрэхүй байхгүй болж байна. Хэрэв бидний малын мэдрэхүйн эрхтэн гэж нэрлэж байгаа тэр зүйл нь мэдрэхүй биш өөр чанар юм бол малын мэдрэхүй гэж нэрлэгдэхгүй, түүнийг өөр ойлголтоор илэрхийлэхийг логик биднээс шаардана. Гэтэл малд мэдрэхүй байдаг. Эцэст нь энд яригдаж байгаа формаль логикийн зүй тогтлыг софизм хэмээн үгүйсгэж болно. Тэгж үгүйсгээгүй тохиолдолд бид “мэдэрч танин мэдэхүй” гэдэг нь буруу ойлголт буюу “мэдэрч танин мэдэхүй” гэж нэрлэдэг тэр юм байхгүй гэдэг хувилбарыг сонгохоос өөр арга байхгүй.

Одоохондоо бид ямарч байсан логик талаасаа “мэдэрч танин мэдэхүй” гэж ярих нь логикийн хувьд буруу болж байгааг, наад зах нь буруу хэллэг болж байгааг харлаа. Харин утгын талаасаа нь авч үзвэл ямар байхыг харъя.

Мэдрэхүйн эрхтнүүдээр өгөгдөж байдаг зүйл нь мэдлэг мөн үү биш гэдгийг нотлохын тулд дараахь туршилт хийж болно: Хүний нүүрний хэмжээнээс том /хэдий чинээ том тусмаа сайн/ цаас, даавуу, нимгэн модон ба төмрөн болон өөр ямар ч хамаагүй материалаар хэд хэдэн хуудсыг энгийн тосон будгаар /нэг өнгөөр/ сайтар аль болох зузаан будна. Зузаан буддаг учир нь будагны цаанаас ямар материал байгааг нь танигдуулахгүй зорилготой юм. Тэгээд өөрийнхөө нүдийг аньж байгаад нүдэндээ ойрхон, 10 орчим см- аас холгүй зайд болж өгвөл хүнээр бариулж байгаад нүдээ дөнгөж хараад анина. Бүх, янз бүрийн материалаар хийсэн боловч бүгд нэг адил

өнгөтэй эдгээр материалыг бүгдийг нь ингэж харж дууссаны дараа бидэнд ганц өнгөнөөс өөр ямар ч өгөгдөл /данный, data/ өнгөний тухай мэдээнээс өөр юм, өөр "мэдлэг" үлдэхгүй байна. Сонсох эрхтнээр авдаг өгөгдлийг авч үзье. Нүдээ мөн аниад ямар нэг юмыг тогшиж үзье. Бидэнд энэ юмнаас зөвхөн тогшиход ямар нэг авиа гаргадаг юм байна гэдгээс өөр өгөгдөл өгөгдөхгүй. Үнэрлэх эрхтнээр буюу хамраар бид харахгүй л бол мөн ганц үнэрийн тухай өгөгдөл л авч байна. Амаар мөн адил. Арьсны мэдрэхүй буюу тэмтрэн мэдрэхүйгээр ч мөн бид ямар нэг объектын тухай бас л ганцхан төрлийн өгөгдөл авна. Ингээд бид хүний мэдрэхүйн таван эрхтнээр бүгдээр нь ямар нэг юм, объектоос ганцхан төрлийн өгөгдөл л авахаас биш бүрэн мэдлэг авахгүй байна.

Мэдрэхүйн эрхтнээр дамжин тархинд очдог өгөгдлийг мэдлэг биш мэдээлэл гэж үзэх буюу мэдээлэл мөн гэж нотлох өөр нэг үндэслэл болгож дараахь бас нэг баримтыг хэлье. Мэдрэхүйн эрхтнээр дамжин тархинд өгөгдөж байгаа мэдээллийг судлагааны ажлын өгөгдөлтэй /данные, data/ харьцуулж болно. Тэгвэл бид судлагаа хийхээр цуглуулсан өгөгдөл гэж ярьдаг материалаа, тоон үзүүлэлтүүдээ мэдлэг, танин мэдэхүй гэж ярьдаг билүү? Бид хүн амын дундаж наслалтыг тогтоох судлагаа хийхээр шийдсэн байлаа гэж бодъё. Тэгээд өгөгдөл цуглууллаа. Энэ өгөгдлүүдийн нэг хэсэг нь магадгүй хамгийн гол, том хэсэг нь хүн амын наслалттай холбоотой асар их тоо, тоон үзүүлэлт байх болно. Энэ их тоог цуглуулснаар л хүн амын дундаж наслалтын тухай мэдлэг өөрөө гараад ирдэггүй биз дээ. Энэ их тоо бол бидний мэдрэхүйн эрхтнээр авдаг өгөгдлүүд буюу мэдээлэл бөгөөд бид энэ мэдээллийг ухаанд өргөн барьдаг билээ. Энэ их тоо бол харьцуулж үзвэл бидний мэдрэхүйгээр дамжин өгөгддөг өнгө, биетийн хатуу чанар ба шингэн чанар, үнэр, амт, дуу авиа, гэдэгтэй адил биш гэж үү?

Энд бас нэг зүйлийг ажиглахгүй өнгөрч болохгүй юм. Бид мөн мал амьтан өдөрт маш олон, магадгүй хэдэн зуун мэдээлэл мэдрэхүйн эрхтнээр авч байдаг. Гэтэл энэ бүхэн бүгд мэдлэг өгдөггүй. Энэ их мэдээллийн ихэнх нь бидний өдөр тутмын амьдралын /биологи- физиологийн ба нийгмийн/ үйл ажиллагаанд мэдлэг болох түвшинд очилгүй зөвхөн мэдээлэл, зарим тохиолдолд бүр дохио сигнал төдийхөн түвшинд хэрэглэгдэж "дуусдаг".

Эдгээр, өмнө дурьдсан зүйлд үндэслэн объектоос зөвхөн мэдрэхүйн эрхтнээр авсан өнгө, дуу авиа, температур, бусад физик шинж, үнэр, амт



зэрэг нь мэдлэг биш зөвхөн өргөн утгаар бол мэдээлэл, бүр нарийвчлан авч үзвэл сигнал гэдгийг нотлож байна. Салангид ганц мэдээ, мэдээлэл нь танин мэдэхүйн, мэдлэгийн үндэслэл төдий болохоос мэдлэг өөрөө биш юм. Ийм салангид мэдээлэл нь нервийн системтэй бүх амьтанд байдаг. Ухамсарлагддаг мэдрэхүй /осознаемое ощущение/ нь толгойн тархи ба толгойн тархины бүрхүүлтэй бүх амьтанд байдаг байна. Психологи, мэдээллийн шинжлэх ухааны мэдлэгээс үзвэл мэдрэхүйн /sensation, ощущение/ өгөгдөл нь мэдлэг гэж хэлэх нь байтугай мэдээлэл ч биш зөвхөн утга агуулаагүй /утгыг нь хараахан өгөөгүй/ сигнал байдаг байна. Кибернетикт сигнал нь мэдээ, мэдээллийг эзэмнэгч /носитель/ юм. "Амьд организмд амьд мэдээ дамжуулдаг холбооны суваг /канал связи/ нь живой нерв"<sup>3</sup> буюу нерв гэдэг үг нь монгол хэл рүү Ш. Лувсанвандангийн редакцийн тольд орчуулснаар "нерв", "мэдрэл", "хий судас" юм байна. Амьд организмд бүх мэдээ /сообщение/ нерв-ийн импульс-ээр дамжуулагддаг гэнэ.

Мэдрэхүйн /sensation/ сигнал, мэдээ нь хүртэхүйд хүрч байж сая утгатай болдог аж. Тэгээд цааш тархинд очиж ухаан, сэдэхүйд ашиглагддаг байна. Ийнхүү объектоос гарч байгаа энерги-сигнал нь /гэрэл, авиа, үнэр, амт/ холбооны суваг /канал связи/ болох мэдрэхүйн эрхтэнээр дамжин хүртэхүйд очиж, түүнээс цааш дамжин мэдээлэл болох хүртлээ ч бас "урт зам" туулдаг байна. Мэдрэхүйн эрхтэнээр буюу холбооны сувгаар үй олон утгатай, утгагүй, /утга агуулсан ба асуулаагүй/ сигнал дамжуулагдаж байдаг. Эдгээр сигналыг мэдээлэл болгон хувиргах, улмаар мэдлэг болгон боловсруулах үйл ажиллагаа нь ухаан, сэдэхүй юм. Тиймээс мэдрэхүйн эрхтэн буюу холбооны сувагаар мэдлэг өөрөө, объектоос шууд дамжин тархинд очдог гэж үзэх үндэсгүй байна. Тиймээс Платоны хэлснээр мэдрэхүйн өгөгдөл нь мэдлэг биш төдийгүй мэдлэгийн сурвалж ч болж чадахгүй харин зөвхөн мэдээллийн сурвалж болж байна. Мэдлэгийн сурвалж нь ч, түүнийг бүтээгч, үйлдвэрлэгч нь ч мэдрэхүй биш зөвхөн ухаан, сэдэхүй дангаараа болдог байна.

Мөн мэдрэхүйн сигнал, мэдээлэл нь мэдлэг өөрөө биш гэдгийг зарим эмпирикүүд ч зөвшөөрч байсан баримт байдаг. Тэдний зарим нь мэдрэхүйн "мэдлэг" нь мэдлэгийн "барилгын тоосго" болдог гэж зүйрлэн үзсэн байдаг. Эндээс үзэхэд мэдрэхүйн таван эрхтний өгөгдлийг зарим эмпирикүүд бүрэн

<sup>3</sup> Пекелис В. 1990. Кибернетика. От А до Я. М.: Детская литература. с. 137

мэдлэг гэж үзээгүй байна шүү дээ. Энэ зүйрлэлээс ч үзсэн тоосго бол барилга биш биз дээ. Тоосго бол тоосго, барилга бол барилга. Үнэхээр мэдлэгийг барилгатай /construction/ зүйрлэж үзсэн нь маш оновчтой зүйрлэл болжээ. Учир нь мэдлэг ч мөн нэг төрлийн өвөрмөц конструкци мөн гэж би боддог. Гэхдээ энэ тухай жич өгүүлнэ.

Нэгэнт ухаан суучихсан хүний хувьд танин мэдэхүйд шаардлагатай бүх өгөгдөл, мэдээллийг заавал мэдрэхүйн энэ таван эрхтнээс авах шаардлага байдаггүй билээ. Энэ баримтыг хүн бүхэн мэднэ. Нэг хүнд түүний урьд өмнө огт үзээгүй нэг бодис гэнэт харуулъя. Тэгэхэд хүн заавал гараараа барьж /тэмтэрч/ үзэлгүйгээр шууд хараад энэ бол хатуу эсвэл шингэн гэж хэлж чадна. Учир нь бидний толгойд хатуу бодис, шингэн бодис хэрхэн оршиж байдаг тухай таньдаг мэдлэг, программ урьдчилан байгаагаас тэр. Мөн хүнд энэ шинэ бодисын гадаад шинж чанараас нь тоочин ярьж өгөхөд, тухайлбал энэ бодис тавиур дээр “зогсож” байна гэж хэлэхэд л хүн, “тааварч өвгөний гурван хүү” гэдэг үлгэрт гардаг шиг, шууд л тэр чинь хатуу бодис байна гэж хэлж, батлаж чадна.

Мөн мэдрэхүйн бүх эрхтнээр дамжуулан авдаг мэдээллүүдийг бид нэгтгэн нэг мэдрэхүйн эрхтнээр авдаг. Энд бид тэмдэг гэдэг бас нэг гайхамшигтай зүйлийн тухай мартаж болохгүй. Хэл яриа ба бичиг үсэг бол хүн төрөлхтний мэдээлэл дамжуулдаг гол, үндсэн тэмдэг мөн. Хэл яриа ба бичиг үсэг гэх мэт тэмдгийг ашиглан бид бүх мэдээллийг “шууд” буюу мэдрэхүйн эрхтнээр дамжуулахгүй авч болно. Мэдрэхүйн таван эрхтнээр дамждаг энергийг, сонсох, харах, амтлах, үнэрлэх, тэмтрэх үйлдлээр олж авдаг мэдээллийг хэлний тэмдэг болгож хувиргаад ганцхан нүдээрээ буюу гэрлийн энергиэр, эсвэл ганцхан чихээрээ буюу авиагаар авч болно. Бас ямар нэг юмны өнгө, үнэр, хатуу зөөлөн, дуу авиа зэргийг тэмдгээр- хэлээр дамжуулан шууд объектоос биш өөр хүнээс авч болдог биз дээ. Магадгүй бүр цаашлаад мэдээллийг мэдрэхүйн замаар дамжуулахгүй ямар нэг багаж хэрэгслийн тусламжтайгаар тархинд шууд дамжуулан өгөх боломж ч байхыг үгүйсгэх аргагүй. Ер нь мэдрэхүйн өгөгдлийг мэдээлэл гэж үзэх үндэслэлийг физиологи, психологийн болон мэдээллийн тухай шинжлэх ухаанд аль эрт бий болсон байна. Мэдрэхүйн эрхтний өгөгдлийг мэдээлэл гэж үзэх үзэл психологид бүр баттай тогтсон байна. Тэр ч бүү хэл оросын зарим

психологичид диалектик материализм, тусгалын онолд үндэслэсэн психологи-оо улайран хамгаалсаар байгаа ч мэдрэхүйн үйл явцыг мэдээлэл, түүнийг хүлээн авах боловсруулах процесс гэж үзэх үзлийг хүлээн авсан байна шүү<sup>4</sup>.

Ингээд мэдрэхүйн эрхтний өгөгдлүүд нь мэдлэг биш мэдээлэл гэж нотлох бас нэг үндэслэгээ болгон дараахь ишлэлийг толилуулъя: Мэдрэхүй /sensation/ гэдэг нь ертөнц дэх сэдэв\* /stimulus/ энергийг илрүүлэгч, кодлогч процесс юм. Сэдэв нь физик энергийг /жишээлбэл, гэрэл, авиа, халуун/ өөрөөсөө ялгаруулж байдаг. Мэдрэхүйн эрхтнүүд нь энэ энергийг илрүүлж, дараа нь түүнийгээ код болгон хувиргаж тархинд дамжуулах боломжтой болгоно. Ертөнцийг "мэдрэхүйн" эхний алхам нь рецепторын эсүүдийн ажил бөгөөд эдгээр нь тодорхой /өгөгдсөн/ хэлбэрийн энергид хариу үзүүлж байдаг. Жишээ нь нүдний торлог бүрхэвч нь гэрэлд, чихний тусгай эсүүд дуу авианд мэдрэмтгий байдаг. Энэхүү физик энерги нь цахилгаан импульст хувирна; энэ цахилгаан импульсээр зөөгддөг мэдээлэл нь мэдрэхүйн эрхтнүүдийг /sense organs/ нервийн төв системтэй холбодог нерв-ийн судлуудаар дамжин тардаг. Гадаад ертөнцийн тухай мэдээлэл нь тархинд ормогц уураган тархины бүрхүүлийн зохих хэсгүүдэд хүрдэг.

\* stimulus, /орос хэлэнд стимул/ гэдэг ойлголтыг "Философийн ухааны орос-монгол нэр томъёо" /улсын нэр томъёоны комиссийн мэдээ № 126-128/ номд "түлхэц, урамшуулал" хэмээн орчуулж ирсэн. Гэтэл сэдэв гэдэг үгийн 1-р утгыг Цэвэлийн тольд "үйл явдлыг үүсгэхэд холбогдсон шалтгаан" гэж тайлбарлсан байх юм. stimulus гэдгийг Лонгманы тольд "something that causes activity" гэсэн байна. Энэ нь монголоор "үйл хөдлөлийн шалтгаан болж байгаа ямар нэг юм" гэсэн нь сэдэв гэдэг монгол үгийн энд авсан утгатай адил байна.

Хүртэхүй /perception/ гэдэг нь мэдрэхүйн /sensory/ мэдээллийг цэгцлэж бас тайлбарлан, түүндээ утга /meaning/ өгөх тархины процесс юм. Бидний нүдний торлог бүрхэвч нь тэнгэрт хурдан хөдлөх мөнгөлөг объектыг мэдээлэх авч, тийрэлтэт онгоцыг "хардаггүй". Бидний чихний хэнгэрэг тодорхой замаар чичирхийлдэг ч Бетховены симфонийг "сонсдоггүй". Юу мэдрэгдсэнийг-

<sup>4</sup> См. Напр.: Петровский А. В., Ярошевский М. Г. 1999. Основы теоретической психологии. М.: Инфра-М., Общая психология. 1998. (курс лекций). /сост. Рогов Е. И./ М.: Владос., Немов Р. С.

мэдрэхүйн мэдээлэл дэхь "харах", "сонсох" гэсэн утга бүхий дүрийг- цэгцэлж, тайлбарлах нь perception юм.

Бидний өдөр тутмын амьдралд sensation and perception гэсэн энэхүү хоёр процесс нь салшгүй чухал юм. Жишээлбэл, тархи мэдээлэл хүлээж авахад тэрээр уг мэдээлэлд автоматаар хариулж, тайлбар өгдөг. Үүнээс болж, орчин үеийн психологчид sensation and perception- хоёрыг мэдээлэл-боловсруулалтын нэгдсэн систем гэж үздэг (Goldstein 1996).<sup>5</sup>

Мэдээллийн тухай шинжлэх ухаан үүсэж ид "залуу" байх үед ертөнц зөвхөн матери, энерги хоёроос биш, матери, энерги, мэдээлэл гурваас бүрддэг гэж зарим хүн "нотлож" байсан 1960- аад оны үед Америкийн психологич Ж.Миллер, Ю.Галантер, К.Прибрам нар кибернетик, информатикийн судлагдахуун ба психологийн судлагдахууны хооронд ямар нэг холбоо байгаа эсэхийг тогтоох зорилготой судалгаагаа хийсэн байна. Кибернетик, информатикийн мэдлэг, үр дүн нь психологийн шинжлэх ухаанд шинэ боломж нээж өгсөн байна. Энэ нь философид ч мөн шинэ боломж нээж өгчээ. Харин философичид тэр боломжийг хайхраагүй өнгөрсөн гэхэд хилсдэхээргүй байна.

Ингээд бид /одоо бол хуучинаар гэж ярьж болох байх/ "мэдэрч танин мэдэхүй", апостериор мэдлэг, "эмпирик мэдлэг" гэж үзэж ирсэн ойлголтуудыг мэдээлэл гэдэг ойлголтоор сольсноор буюу өөрөөр хэлбэл хүн амьтны мэдрэхүйн өгөгдлүүд нь танин мэдэхүй, мэдлэг биш мэдээлэл байсныг таньж мэдсэнээр эпистемологид танин мэдэхүй, арга зүйн нилээд давуутай /өмнөхтэй харьцуулбал/ хандлагыг олж авч байна. Үүнээс бид энэ бүлэгт оюуны үзэгдлийг судлахад арга зүйн ач холбогдол бүхий ганцхан зүйлийн тухай ярья. Бусдыг нь дараахь бүлэгт үзэх болно.

Бид рационал танин мэдэхүй буюу ер нь хүний ухааныг ямар нэг юмаар орлуулж чадахгүй, лав одоогийн шинжлэх ухаан чадахгүй байгаа билээ. Хүний оюун нь өнөөдөр танин мэдэхүйн үүднээс доторхи нууцаа маш бага дэлгэсэн, бусад объектуудтай харьцуулахад огт дэлгээгүй гэж хэлж болохоор, яг л кибернетикийн "хар хайрцаг" шиг байгаа юм. Түүний дотоод процессыг судлах шинжлэх ухааны боломж өнөөдөр эрс хязгаардагдмал юм байна. Тиймээс бид өнөөдөр оюуны, сэдэхүйн, ухааны судалгаанд бусад шинжлэх ухааны болон кибернетик, информатик гэх мэт боломжтой бүх

<sup>5</sup> Santrock J. W. (1997). Psychology. (4<sup>th</sup> ed.) Brown & Benchmark Publishers

аргууд, арга зүй, модель зайлшгүй хэрэглэх ёстой. Бид философийг хөгжүүлэе гэвэл өнөөдөр эртний Грек, шинэ үеийн философийн түвшинд ярьж бичдэгээсээ татгалзаж, орчин үеийн шинжлэх ухаан руу бага сага ч болов хандахаас өөр арга зам байхгүй. Бүх шинжлэх ухааны судлагдахуунаас хамгийн ээдрээтэй нь биологийн организм байдаг гэж эрдэмтэд хүлээн зөвшөөрдөг юм байна. Зөвхөн биологийн систем л хамгийн их мэдээллийг цуглуулж, хадгалж, боловсруулж чаддагаараа гайхуулдаг информатикийн "омогийг дардаг" байна. Хүний тархи нь тоолохын аргагүй олон янзаар хоорондоо холбогдсон ойролцоогоор 12-14 тэрбум нейроноос тогтдог гэж үзэж байтал тийм биш болж зөвхөн бага тархи л дангаараа 100 тэрбум эсээс тогтдог болжээ. Оюуны үзэгдлийн үндэс суурь болдог тархины физиологийн асуудлыг зөвхөн тоон талаас нь авч үзэхэд л ийм, асар их төвөгтэй байдаг байна. Гэтэл философид ярьдаг оюуныг, сэдэхүйг, ухааныг судлах нь хүний танин мэдэх чадвартай харьцуулахад бүр ч их ээдрээтэй, төвөгтэй юм. Иймээс хүний оюун таньж мэдэгдсэн талаасаа ч зүйрлэж үзвэл "хар хайрцаг", судлагааны арга зүйн талаасаа ч "хар хайрцгийн" модель- оор судлагдахаас өөр аргагүй байгаа юм.

"Хар хайрцаг" гэдэг ойлголтыг кибернетикт удирдагддаг системийг модель болгох, загварчлах асуудлыг шийдэх ба гарган тавихад ашиглаж иржээ. "Хар хайрцаг бол гаднаас ажиглагч, судлаачид орцын ба гарцын хэмжигдэхүүн нь мэдэгдэж харин дотоод байгууламж, бүтэц нь мэдэгдээгүй систем" юм.<sup>6</sup> Системийн поведение-гийн тухай маш чухал зарим дүгнэлтийг орц- хэмжигдэхүүн нь гарц- хэмжигдэхүүн болохдоо өөрчлөгдсөн өөрчлөлтийг үндэслэн гаргаж авдаг байна. Ийм хандлага нь дотоод бүтэц, байгууламж нь мэдэгдэхгүй байгаа буюу танин мэдэгдээгүй, эсвэл системийн бүрдэл хэсгүүдийн шинж ба тэдний хоорондын холбооны бүтцээс поведение-г нь бид дүгнэн гаргаж чадахгүй хэт ээдрээтэй системүүдийг бодож судлах боломж олгодог байна. Жишээ нь ургамлын молекул бүтцийг нь биш поведение-г нь судлан агротехникийг боловсруулдаг байна.

Философи, ер нь оюун судлалд шинжлэх ухааны өнөөгийн түвшинд "хар хайрцгийн" арга, арга зүйг хэрэглэхээс илүү сайн юм бараг л үгүй гэж хэлэхээр байна. Хүний уураг тархины биологи, физиологийн байгууламж, бүтэц, тогтоцыг мэддэг болсон үед ч оюун ба ухааны нууц тайлагдахгүй байх

<sup>6</sup> Лернер, А. Я. 1967. Начало кибернетики. М., с. 43.

боломжтойг эртэмтэд онолын хувьд зөвшөөрдөг шүү дээ. Тиймээс хар хайрцгийн арга нь бидэнд нилээд урт хугацааны туршид “хань” болох магад.

“Информатик хандлагын” үүднээс юуны өмнө оюуны үйл ажиллагаагаар, танин мэдэхүйн процесс, мэдлэгийн асуудлыг “хар хайрцгийн” аргаар буюу мэдээллийн орц, гарцаар нь судлах нэг боломжийг олж авч байна. Цааш нь бидэнд танин мэдэхүйд “мэдээлэл” гэдэг ойлголтыг хэрэглэсээр танин мэдэхүй, мэдлэгийн тухай асуудлыг судлах, авч үзэх бас нэг шинэ боломж нээгдэж байна.

Энэ үүднээс “рационал танин мэдэхүй” буюу априори мэдлэг ч мэдрэхүйн эрхтнээс өгөгддөг мэдээлээс өмнө, “цэвэр” байдлаар оршиж байдаг гэсэн гэнэн төсөөллөөс ангижрах болно. Ингэхдээ мэдээж орон /space/, хугацаа /time/, шалтгаалахуй /causality/, хөдөлгөөн /motion/ зэрэг ойлголт нь Кантын үзсэн шиг мэдрэхүй, туршлагын өмнө, мэдрэхүйн мэдээллээс ангид, цэврээрээ оршиж байдаггүй гэж үзнэ. Орон, хугацаа, шалтгаалахуй, хөдөлгөөн зэргийг хүн мөн мэдрэхүйн эрхтнээр, тухайлбал хүртэхүйн тусламжаар олж авдгийг өнөөгийн психологи нотлож байна<sup>7</sup>. Иймээс рационал танин мэдэхүй гэдэг ойлголтыг ч бид мэдрэхүйн мэдээллээс ангид авч үзэхгүй бөгөөд тиймээс “информатик” хандлагын хувьд “эмпирик, мэдэрч танин мэдэхүй ба рационал, сэдэж танин мэдэхүй, мэдлэг” гэх мэт ойлголт, онолууд байхгүй ба зөвхөн ямар ч тодотголгүй “танин мэдэхүй” гэсэн нэгдмэл ойлголтыг хэрэглэх болно. Энэ үүднээс танин мэдэхүй нь зөвхөн объектоос өгөгдсөн, авсан мэдээллийг сэдэхүйд боловсруулан аль болох бодот объектодоо тохирсон, түүнтэй адилсал бүхий оюуны конструкци /constuction/, модель бүтээх процесс юм. Мэдлэг бол сонгон авсан объектийг дуурайлган /түүнтэй адилсуулан/ бүтээсэн объектын конструкци, модель юм.

Энэ үүднээс эмпирик ба рационал танин мэдэхүй, эмпирик, апостериори мэдлэг ба рационал, априори мэдлэг гэж хоёр өөр юм байхгүй гэсэн үг. Зөвхөн мэдрэхүйн эрхтнээр авсан мэдээллийг ухаанд, сэдэхүйд ашиглан, боловсруулан мэдлэг үйлдвэрлэдэг нэг танин мэдэхүй л бидэнд заяажээ.

<sup>7</sup> Немов Р. С. 1999. Психология. Кн. 1. Общие основы психологии. М.: Владос, и др.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

- Вольф Р. 2002. Философийн тухай. УБ.: Монсудар.
- Философи эхлэн суралцах бичиг. 2000. УБ.: МУИС.
- Философи. Сурах бичиг. 2002. /ред.: Ц. Гомбосүрэн, М. Отгонбаяр. УБ.: МУИС.
- Антология мировой философии. М., 1969. в 4 т., т. 1., ч. 1.
- Винер Н. 1983. Кибернетика. М.: Наука.
- Лернер, А. Я. 1967. Начало кибернетики. М.: Наука.
- Немов Р. С. 1999. Психология. Кн. 1. Общие основы психологии. М.: Владос.
- Общая психология 1998. (курс лекций). /сост. Рогов Е. И./ М.: Владос.
- Пекелис В. 1990. Кибернетика. От А до Я. М.: Детская литература.
- Петровский А. В., Ярошевский М. Г. 1999. Основы теоретической психологии. М.: Инфра-М.
- Чанышев А. Н. 1981. Курс лекций по древней философии. М.: Высшая школа.
- Miller Ed. L. (1987). Questions that matter. McGraw-Hill, Inc.
- Nozick R. (1994). Philosophical explanations. (11<sup>th</sup> printing) Cambridge: Harvard University Press.
- Santrock J. W. (1997). Psychology. (5<sup>th</sup> ed.) Chicago, Toronto, Tokyo, London: Brown & Benchmark Publishers.